

“ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2025 оны 5-р сарын 10-ны өдрийн хурлын
12 тоот тогтоодын хавсралт №2



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ЖУРАМ

Нэг. Зорилго

- 1.1 ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны зорилго нь (1) компанийн дотоод хяналт, журмууд стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, (2) эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, (3) хараат бус аудиторын мэргэжлийн ур чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.
- 1.2 Эрсдэлийн удирдлагын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд тодорхой асуудлаар санал, дүгнэлт гарган төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хууль тогтоомжид заасан зарим асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байна.

Хоёр. Бүрэлдэхүүн

- 2.1 Эрсдэлийн удирдлагын хороо нь 3-аас доошгүй ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь хараат бус ТУЗ-ийн гишүүн байна.
- 2.2 Эрсдэлийн удирдлагын хорооны дарга, гишүүдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооноос санал болгож, ТУЗ-ийн хурлаар томилно.
- 2.3 Хорооны дарга, гишүүд нь дараагийн дарга, гишүүд албан ёсоор томилогдож, ТУЗ-өөр хорооны гишүүнээс чөлөөлөх шийдвэр гартал хорооны гишүүний ажил үүргээ гүйцэтгэнэ.
- 2.4 Хорооны гишүүн бүр нь санхүүгийн боловсролтой байх бөгөөд хамгийн багадаа нэг гишүүн нь санхүү, эдийн засагч мэргэжилтэй байна.

Гурав. Хурал

- 3.1 Эрсдэлийн удирдлагын хороо нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай нөхцөлд нэмэлт хурлыг зохион байгуулж болно.
- 3.2 Хуралд гишүүдийн 2/3 оролцсоноор хүчин төгөлдөр болох ба гишүүд хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хурлыг гишүүд харилцан бие биеэ сонсож, санал бодлоо илэрхийлж болох арга хэрэгслийг ашиглан утсаар эсвэл видео хэлбэрээр зохион байгуулах эсвэл хуралд оролцоогүй гишүүний саналыг бичгээр авсан байж болно.
- 3.3 Хорооны хуралд шаардлагатай тохиолдолд компанийн удирдлагууд болон ажилтнууд, гаднын зөвлөгчдийг оролцуулж болно.
- 3.4 Хорооны дарга нь хорооны хурлын тов, хурлаар хэлэлцэх асуудлыг урьдчилан тодорхойлох бөгөөд гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудалд оруулах саналаа хурал хуралдахаас ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж болно.
- 3.5 Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээ, материалыг урьдчилан гаргуулж, бүх гишүүд урьдчилан танилцсаны үндсэн дээр хэлэлцүүлэг явагдана.
- 3.6 Хороо нь хурлаар хэлэлцсэн асуудлынхаа хүрээнд дүгнэлт, зөвлөмж, удирдамж гаргаж, холбогдох дүрэм, журмыг батална.

Дөрөв. Хорооны чиг үүрэг

- 4.1 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой чиг үүрэг

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлж, эрсдлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавина. Энэ хүрээнд хороо дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.Үүнд:

- 4.3.1 Компанийн эрсдэлийг удирдах бодлого, стратегийг тодорхойлох, тэдгээр нь шаардлага хангахуйц, үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавих
 - 4.3.2 Эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт, төлөвлөгөөг батлах
 - 4.3.3 Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай удирдамж, чиглэлийг өгөх.
- 4.2 Тайлагналын үүрэг
- Эрсдэлийн удирдлагын хороо нь үйл ажиллагаагаа ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлagnana:
- 4.4.1 Дотоод, гадаад хяналтын тогтолцоогоор болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хяналтын явцад илэрсэн аливаа зөрчил, дутагдал болон тэдгээрийг арилгах арга хэмжээний талаар ТУЗ-д байнга тайлagnah
 - 4.4.2 Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын тэмдэглэл, шалгалтын тайлан, дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр саадгүй танилцуулах
 - 4.4.3 Хорооны гишүүдийн танилцуулга, намтар, хорооны үйл ажиллагааны жилийн тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах
 - 4.4.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн бол дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах
- 4.5 Компанийн нууцыг хадгалах үүрэг
- 4.5.1 Хорооны гишүүд нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан эсвэл шалгалтаар илрүүлсэн аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

Тав. Эрх мэдэл

- 5.1 Эрсдэлийн удирдлагын хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон дараах эрхтэй байна.
- 5.1.1 Байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангах, хянах, шаардлагатай арга хэмжээ авах зорилгоор эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх нэгжийн бүрэлдэхүүнийг томилох, үүрэг даалгавар өгөх
 - 5.1.2 Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагааны талаар дүгнэлт гаргах, зөрчил гаргасан бол түүнийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг түдгэлзүүлэх саналыг ТУЗ-д оруулах
 - 5.1.3 Хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, баримтыг саадгүй гаргуулах, холбогдох мэдээллийг гаргаж өгөөгүй ажилтан албан хаагчдад хариуцлага тооцох саналыг гүйцэтгэх удирдлагад оруулах

Зургаа. Журамд өөрчлөлт оруулах

- 6.1 Хороо нь энэхүү дүрмийн заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТУЗ-д санал оруулж батлуулж болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ